

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2016 ОНЫ  
ЭРХ ЗҮЙН АЖЛЫН ТАЙЛАН, 2017 ОНД ХАМТРАН  
АЖИЛЛАХ САНАЛ

2016 оны 12 дугаар сар 13

Нэг. 2016 оны ажлын тайлан

Тус байгууллага нь дараахь хууль, эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг. Үүнд:

А. Төрийн захиргааны байгууллагынхаа хувьд өдөр тутмын үйл ажиллагаанд:

- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль,
- Төрийн албаны тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Захиргааны ерөнхий хууль,
- Хөдөлмөрийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль,
- Нийгмийн даатгалын тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Авилгын эсрэг хууль,
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай,
- Архивын тухай хууль,
- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай,
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай,
- Эдгээр хуулиудыг мөрдөхтэй холбогдон гарсан бусад эрх зүйн актууд

Б. Үндсэн үйл ажиллагаа болох дотоод аудитын үйл ажиллагаанд:

- Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан Дотоод аудитын дүрэм,
- Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт,
- Аудит хийж буй байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой салбарын хуулиуд,
- Эдгээр хуулиудыг мөрдөхтэй холбогдон гарсан бусад эрх зүйн актууд

Нийслэлийн Дотоод аудитын алба нь 2016 онд дээрх хууль, эрх зүйн актын хүрээнд дараах байдлаар ажиллалаа. Үүнд:

1. Байгууллагын дотооддоо нийт 8 дүрэм, журмыг мөрдөн ажиллаж байна. Байгууллагын бүтэц, орон тооны хязгаар өөрчлөгдсөнтэй холбоотойгоор байгууллагын дүрэм болон дотооддоо батлан мөрддөг 1 журмыг шинэчлэн боловсруулж мөрдөж байна.

2. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд байгууллагын дарга үйл ажиллагааны болон хүний нөөцийн чиглэлээр тус бүр 20 тушаал гаргасан. Эдгээр тушаалуудын хуулийн үндэслэлийг зөв тодорхойлох талаар анхаарч, шаардлагатай үед

НЗДТГ-ын ХЭЗХ-ийн мэргэжилтнүүдээс зөвлөгөө авч хамтарч ажилласан. Мөн байгууллагын даргын нийт 8 тушаалд кодификаци хийн, бүртгэл хөтөлсөн.

3. Захиргааны ерөнхий хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган ажиллаж байна. Тус хуулийн 27 зүйлд заасны дагуу бүтцийн өөрчлөлт, орон тооны хязгаар өөрчлөгдсөнтэй холбоотойгоор сонсох ажиллагааг 3 удаа хийж, тэмдэглэл хөтөлсөн.

4. Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв хөтөлж, тайлан балансыг хуулийн хугацаанд нь зохих байгууллагад тайлагнан ажилласнаар аливаа өглөг, авлагагүй ажиллаж, хөндлөнгийн аудитаар санхүүгийн тайлагналын зөрчилгүй дүгнэлттэй ажилласан. Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу 4 жил тутамд зохион байгуулагддаг Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулсан. Мөн хуулийн дагуу өмч эзэмшлийн тухай гэрээг 100%-ийн үнэлгээтэй дүгнүүлсэн.

5. Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу тайлан мэдээг хуулийн хугацаанд нь тогтмол гаргаж, байгууллагаас нийт 54.1 сая төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлд, 22.0 сая төгрөгийг хувь хүний орлогын татварт шилжүүлсэн. Мөн Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс хийсэн шалгалтаар зөрчилгүй ажилласан.

6. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хүрээнд шилэн дансны цахим хуудас болон байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт хуулинд заасны дагуу санхүүгийн мэдээллийг тогтмол шинэчлэн байршуулсан.

7. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд авлигын эсрэг байгууллагын төлөвлөгөө гарган ажиллаж байна. Давхардсан тоогоор 14 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг, 8 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, 103 ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг хуулийн хугацаанд хүлээн авч бүртгэсэн.

8. Архивын тухай хуулийн дагуу байгууллагын архивыг бүрдүүлж, 2015 оны нийт 164 хадгаламжийн нэгжийг архивт хүлээн авч, нөхөн бүрдүүлэлт хийсэн. Мөн хөтлөх хэргийн нэрийн жагсаалтаар баталсан зарим хадгаламжийн нэгжүүдийн цахим нөхөн бүрдүүлэлтийг хийлээ.

9. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд өргөдөл, гомдлын smartcity нэгдсэн системээр иргэдийн 28 өргөдлийг хүлээн авч, хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол саналыг богино хугацаанд шийдвэрлэхээр бүхий л боломжоороо ажиллаж байгаа бөгөөд тус албаны өргөдөл гомдол шийдвэрлэлт 0.88 хувьтай байгаа нь нийслэлийн дунджаас 0.03 хувиар дээгүүр байна.

10. Үндсэн чиг үүргийнхээ дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 29 байгууллагын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн, санхүүгийн тайлан тэнцэлд санхүүгийн дотоод аудит хийж, холбогдох хууль, эрх зүйн акт, стандартыг мөрдөөгүй зөрчлийг илрүүлэн зөвлөмж хүргүүлэн ажиллаж байна.

11. Дараахь хуулиудын төсөлд санал боловсруулж өгсөн. Үүнд:

- Улсын салбарын дотоод аудитын тухай хуулийн төсөлд санал боловсруулан Улсын салбарын Дотоод аудитын нэгдсэн зөвлөгөөн дээр Сангийн яаманд танилцуулсан.

- “Нийслэлийн эрх зүйн байдлын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, энэ хуультай нийцүүлэн зарим хуульд өөрчлөлт оруулах төсөлд оруулах саналыг НЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэст албан бичгээр хүргүүлсэн.

12. Гэмт хэргээс урьдчилэн сэргийлэх, эрх зүйн сургалт сурталчилгаа, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор албан хэрэгцээнд шаардлагатай хууль, эрх зүйн бичил номын сантай болж, түүнийг баяжуулан ашиглаж байна. Мөн энэ чиглэлээр дараахь сургалтуудад холбогдох албан хаагчид хамрагдсан. Үүнд:

- НЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсээс зохион байгуулсан нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хуульчдын дунд явуулсан Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга болон УИХ-аас сүүлийн үед баталсан хуулиудын танилцуулга вакум сургалтад 1 албан хаагч,
- Захиргааны ерөнхий хуулийн танилцуулга сургалтад 22 албан хаагч,
- Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн танилцуулга сургалт байгууллагын дарга,
- Авлигын эсрэг хуулийн сургалтад байгууллагын дарга,,
- Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын сургалтад 1 албан хаагч,
- Компанийн засаглалын сургалтад 7 албан хаагч,
- Хуульчийн үргэлжилсэн сургалтад 1 албан хаагч тус тус оролцсон.

13. Шаардлагатай хууль, эрх зүйн актуудыг албан хаагчдад танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьснаар:

- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын 2015 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний шалгалтаар “БҮРЭН ХАНГАЛТТАЙ” үнэлгээ авсан.
- Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар 1 гомдол, гарсан ч байгууллагын дэргэдэх ёс зүйн хороогоор хэлэлцэн үндэслэлгүй гэж үзэн, гомдол гаргагчид танилцуулсан.

14. Дээд газрын нийт 8 тогтоол, шийдвэрийн 22 заалтын хэрэгжилт, биелэлтийг тогтоосон хугацаанд гарган, зохих байгууллагад хүргүүлж байна.

Хоёр. 2017 онд хамтран ажиллах санал

Тус байгууллагаас 2017 онд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэстэй дараах чиглэлээр хамтран ажиллах саналтай байна. Үүнд:

1. Байгууллагын үйл ажиллагааны болон дотоод аудитын явцад эргэлзээтэй, маргаантай асуудлыг хууль зүйн үндэслэлтэйгээр шийдвэрлэхэд зөвлөх, мэдээлэл өгөх, эрх зүйн туслалцаа үзүүлэх,

2. Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд нийтлэг гарч буй зөрчилтэй холбоотой хууль, эрх зүйн актын талаар нэг мөр ойлголт өгөх, сурталчлах ажлыг хамтран зохион байгуулах саналтай байна.

ХЯНАЖ, ТАНИЛЦСАН:

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЖАВЗАН

ТАЙЛАН БИЧСЭН:

ЗАХИРГАА, ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Я.САРАНСҮХ